



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар A/050

Хэрлэн сум

Хүнд даацын авто тээврийн хэрэгслийн
хөдөлгөөнийг хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3, 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих өрөнхий шаардлага” MNS4598:2020 стандартын хэрэгжилтийг хангуулах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж авто зам, гүүрийн байгууламжийг эвдрэлд оруулж байгааг шалган тогтоож, зөрчлийг арилгуулах, авто зам, замын байгууламжийг хамгаалах зорилгоор даац хэтрүүлэн ачаа тээвэрлэсэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хориглосугай.

2. Хөдөлгөөн хориглосон хугацаанд замын хөдөлгөөнд оролцож байгаа том оврын, хүнд даацын авто тээврийн хэрэгсэл бүрийг хяналтад хамруулж, илэрсэн зөрчлийг арилгуулан замын хөдөлгөөнд оролцуулах, холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, хүнд даацын авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн хязгаарласан тухай мэдээг ачаа үүсгэгч, тээвэрлэгч болон нийтэд хүргэх, зам, тээврийн хяналтын үйл ажиллагааг эрчимжуулж, зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (Д.Батхүү), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Сүнгээ), Авто тээврийн төвийн дарга (Ц.Бат-Эрдэнэ), “Харгуй” ТӨХК-ийн захирал (Л.Бат-Октябрь), Зам тээврийн хөгжлийн төвийн салбар “Мөрөн ТАЦ”-ын ахлагч (Э.Амарсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох байгууллагын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжүүлж буй ажлын мэдээ, мэдээллийг 7 хоног бүр танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



№ 2319110009